

## 6

## ЭКОЛОГИЙН МЭДРЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

## Н. Сонинтамир

Дэлхий дахины нийт хүн ардын сэтгэлийг түгшээсэн түгээмэл асуудлуудын тухай ярьж, түүнийг судалдаг шинжлэх ухаан бий болон хөгжсөнөөс хойш 30 гаруй жил өнгөрлөө. Энэ үйл ажиллагааны шууд үр дүнд улс орны хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас хүн, байгаль орчин, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийг цогц байдлаар харилцан хамааралтай авч үздэг тогтвортой хөгжлийн шинэ хандлага руу хүн төрөлхтөн шилжин ороод арван жил болж байна.

Шинжлэх ухааны бүтээлүүдэд түгээмэл асуудлуудыг дараах гурван том бүлэгт ангилдаг хэвшил нэгэнт тогтжээ.<sup>1</sup>

- Үндэстэн хоорондын нийгмийн түгээмэл асуудлууд (дайн, тэр тусмаа цөмийн дайнаас урьдчилан сэргийлэх; цөмийн зэвсэггүй, хүч үл хэрэглэх дэлхий ертөнцийг тогтоох; шинэ шудрага, ухаалаг нийтлэг дэг журмыг бүрдүүлэх; хөгжингүй болон хөгжиж буй орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшний эрс ялгааг даван туулах гэх мэт)
- Хүн байгалийн харилцаан дахь түгээмэл асуудлууд (экологийн асуудлууд; соёл иргэншил оршин тогтнох, хөгжиж дэвшихэд зайлшгүй шаардлагатай байгалийн нөөцөөр хүн төрөлхтнийг хангах; далайн нөөц болон сансрын орон зайг зүй зохистой ашиглах)
- Хүн ба нийгмийн харилцаан дахь түгээмэл асуудлууд (хүн ам зүйн асуудал; шинжлэх ухаан технологийн дэвшлийн ололтыг хүмүүнлэгээр ашиглаж, боловсрол эрүүл мэндийг хөгжүүлэх; мэдээллийн нийгэмд хүний дасан зохицох чадвар болон техник технологийн дэвшлийн сөрөг үр дүнг урьдчилан харж, түүнээс урьдчилан сэргийлэх нийгэм-эдийн засаг, хууль эрх зүйн механизмуудыг бүрдүүлэх)

<sup>1</sup> Чумаков А.Н. Философия глобальных проблем. М., 1994, с. 131

Эдгээр түгээмэл асуудлууд нь өнөө үед байгаль, техник, эдийн засаг, нийгэм хүмүүнлэг, анагаах ухаан зэрэг шинжлэх ухаануудын судалгааны объект хэдийнээ болж, чиглэл бүрээр судалгааны ажлууд хувь хүн, эрдэмтэдээс аваад олон нийтийн байгууллагууд, олон улсын түвшинд өргөнөөр хийгдэж байна.

Түгээмэл асуудлуудыг танин мэдэх, тэдгээрийг шийдэх стратегийг боловсруулах хүрээнд хийгдсэн судалгааны ажлууд цаашид амжилтанд хүрч, соёл иргэншлийг аврах зорилгодоо ахиц гаргахад нь хурцаар тавигдаж байгаа өнөөгийн шаардлага бол зөвхөн салбар шинжлэх ухаанууд төдийгүй суурь шинжлэх ухаанууд энэ асуудлаар нэгдэн нийлж, хамтран ажиллах явдал юм. IGBP Science сэтгүүл, дэлхий дээрх амьдралыг дэмжиж тэтгэх системийг ойлгох зорилго бүхий бие даасан шинэ интеграл шинжлэх ухааны тухай, шинэ арга хандлагыг хөгжүүлэх тухай бичиж<sup>2</sup>, Монголын зарим нэг эрдэмтэд "ирээдүйгээ харсан эдийн засагч байя гэвэл байгаль нийгэмтэй уялдаа холбоотой судалгааны ажил хийх хэрэгтэй"<sup>3</sup> гэж зөвлөж байгаа нь энэ уриа дуудлагын илрэл буюу. Байгалийн ба нийгмийн шинжлэх ухаануудын хоорондхи интеграц гэсэн даяарчлалын нэгэн шинэ хэлбэр түрэн гарч ирж байж магадгүй.

Энэ шаардлага нь түгээмэл асуудлуудын мөн чанар, динамик, дотоод хэлхээ холбооноос урган гарч байна. Орон нутаг юмуу бүс нутгийн асуудлуудаас түгээмэл асуудлуудыг ялгаж өгч байдаг гол шалгууруудын тухайн ойлголт өргөжин тэлж, түгээмэл асуудлууд нь (1) дэлхий нийтийг хамарсан, бүх улс үндэстэнд хамаатай, (2) бүх нийтээр хүч анхаарлаа төвлөрүүлж байж шийдэх боломжтой асуудлууд болоод зогсохгүй (3) соёл иргэншлийн хувьслын суурь үйл явцуудтай салшгүй холбоотой, (4) мөн өөр хоорондоо нягт харилцан хамааралтай, аль нэг асуудлыг нь ганцаарчлан тусад нь шийдэх боломжгүй, цогцолбороор хандахыг шаардсан асуудлууд болоод байна.

Хүн байгалийн харилцаан дахь түгээмэл асуудлууд дундаас өнөө үед экологийн асуудал хамгийн хурцаар тавигдаж байна. Олон төрөл зүйлийн ургамал амьтан үгүй болсон, агаар дахь хүлэмжийн хийн хэмжээ сүүлийн арван жилд урьд өмнө үзэгдээгүйгээр хэд дахин нэмэгдсэн, биосфер өөрийн нөхөн сэргээх чадвараа алдсан тухай судалгааны олон тоо баримт дурьдалтгүйгээр л, өнөөгийн нөхцөл байдал биднийг Байгаль дэлхий минь яаж байна даа гэж бодоход аргагүй хүргэж байна. Өнгөрсөн зуныг л гэхэд Европын улсууд усан дунд, бид ган дунд өнгөрүүлээ. "Орчин үеийн соёл иргэншил нэг бол өөрчлөгдөх ёстой, эс тэгвээс үгүй болно"<sup>4</sup> гэсэн А.Печчейгийн үг өнөөгийн байдлын мөн чанарыг тодорхойлсон хэвээр.

Экологийн асуудлыг зөвхөн биосфер (агаар, ус, чулуулаг, хөрс, ургамал, амьтан)-ийн бохирдол хохиролын талаас биш философи, ёс зүй, эдийн засаг, техник, улс төрийн шинжлэх ухаануудын үүднээс цогцолбороор ойлгох, судлах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл нийгмийн эдгээр шинжлэх ухаануудыг экологийн мэдрэмжтэй болгох хэрэгтэй гэсэн үг. Шинжлэх ухаан, хүний оюун санааны үнэт зүйлс экологийн мэдрэмжтэй болсон тэр цагт л хүний амьдралын материаллаг талыг зүй зохистой экологижуулах<sup>5</sup> (биосферт хоргүй болгох) үйлс маань бодитой амжилт олно.

Нийгмийн шинжлэх ухаанууд экологийн мэдрэмжтэй болох үйл явцад эдийн засгийн сэтгэлгээний экологижилт тэргүүлэх ач холбогдолтой. Экологийн асуудал нь орчин үеийн

<sup>2</sup> Marking Earth System Science // IGBP Science, 2001, № 4, p. 23

<sup>3</sup> Д.Давагдорж "Лидер эдийн засагч байя гэвэл байгаль нийгмээ судал" / Тулхтай хөгжил-Монголын ирээдүй. 2002, УБ., х. 81.

<sup>4</sup> Сидорина Т.Ю. Римский клуб: 25 лет со дня основания // Вопросы философии. 1995, №3, с. 65.

<sup>5</sup> Экологийн асуудлыг шийдэх, хүний амьдралын материаллаг талыг экологижуулах үүднээс шинжлэх ухаан технологийн дэвшлийн ололтоос татгалзах, эртний уламжилалт үйлдвэрлэлийн аргад шилжих, эдийн засгийн өсөлтийг тэглэх, эсвэл биосферыг техносферээр солих гэх мэт хувилбарууд байдаг бөгөөд эдгээр нь хүмүүнлэг биш юм.

зах зээлийн механизмаас экологийн болон эдийн засгийн хандлагуудыг зайлшгүй хослуулахыг шаардаж байна. Эдийн засгийн хөгжил хүний ашиг сонирхол, аюулгүй байдлыг хамгаалах асуудлуудтай нийцэж явагдах ёстой бөгөөд өнөөдөр «бага зардал» гэсэн шалгуур биш, харин хүн ба хүрээлэн байгаа орчинд «бага хохирол» учруулах гэсэн шалгуур тэргүүн эгнээнд тавигдах ёстой.

Хувийн эгоизм, рационализм өөрийн эрхгүй нийгмийг хөгжүүлдэг, эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрээр зах зээлийн үнэ тогтоож, ашиг хувиарлагдаж улмаар салбар хооронд капиталын шилжих хөдөлгөөн зохицуулагдан эдийн засаг тэнцвэржиж байдаг гэсэн агуулга бүхий суурь концепци одоогоор эдийн засагчдад нөлөөтэй хэвээр байна. Энэ хүчтэй далд гарыг хэрхэн экологийн мэдрэмжтэй болгох вэ?

Юуны өмнө эдийн засгийн харилцаанд оролцогчдын оюун санааны амьдрал, соёлын үнэт зүйлсийг экологижуулах хэрэгтэй. Хүнд хүн-байгалийн хүйн холбоог ойлгуулах, экологийн мэдлэг олгох, түүнийг хайрлаж хамгаалах сэтгэл зүтгэлтэй болгох тийм иргэний хүмүүжил олгох нь чухал. Энэ үйлсэд төр, боловсролын байгууллагууд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх бөгөөд гэр бүл шашины байгууллагууд ч шийдвэрлэх нөлөөтэй юм.

Нөгөө талаас эдийн засаг маань аль ч түвшиндээ нэгэнт удирдлага зохицуулалттай байдаг билээ. Эдийн засаг дахь төрийн оролцоо зайлшгүй болохыг тайлбарлахад сонирхолтой үндэслэл болдог «туулайчлагч» (The Free-Rider), эерэг гадаад нөлөө (spillover benefits), трансакцийн зардлууд (transaction costs) гэх мэт ойлголтууд байдаг бөгөөд тэдний эгнээ ойрын үед экологийн агуулагаар баяжих нь лавтай.

Орчин үеийн эдийн засагт төр (1) эдийн засаг дахь институт<sup>6</sup>-уудыг бүрдүүлэх, (2) орлогыг хуваарилах, (3) эдийн засгийн өсөлтийг дэмжих гэсэн үндсэн гурван бүлэг үүрэг гүйцэтгэдэг.<sup>7,8</sup>

Төр эдгээр үүргүүдээ биелүүлэх явцад байгаль орчинд хоргүй халгүй байх, байгалийн нөөцийг ариглан хэмнэх, хайрлаж хамгаалах, нөхөн сэргээх асуудлуудыг бүх талаас нь бодож тусгасан, уялдан зохицуулсан бодлого баримталж удирдан жолоодох хэрэгтэй.

Гариг дэлхийгээ хамгаалан хөгжих гэсэн хүн төрөлхтний хөгжлийн гольдрол руу Монгол улс нэгдэн орж, XXI зууны тогтвортой хөгжлийн чиг хандлагыг тодорхой хэмжээгээр тусгасан хөгжлийн баримтлалууд боловсруулж ирсэн. Тухайлбал УИХ-аар 1994 онд баталсан «Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал», 1996 онд баталсан «Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал»-ыг дурьдаж болно. «Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр»-ийг 1998 онд батлаад одоо даян дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн төрөөс баримтлах бодлогын үндэсийг боловсруулж байна. Энэ бүхний дагуу байгаль орчны таагүй өөрчлөлтийн гол хандлага, цөлжилт, элсний нүүдэл, ой, ус, бэлчээрийн нөөцийн хомсдолтой тэмцэх, улс орны хөгжлийг дэлхийн уур амьсгалын ерөнхий өөрчлөлтийн хандлагад дасан зохицох чадвартай болгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах юм.

<sup>6</sup> Институт гэдэг нь үйл ажиллагааны чиглэл бүхий тодорхой байгууллагуудаас гадна тухайн нийгэмд үйлчилж буй хууль дүрэм журмын систем, мөн хуульчлагдаагүй боловч хүмүүсийн ухамсар оюун санаа, үйл ажиллагаанд дадал зуршил болон тогтсон уламжлалт харилцаануудыг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм.  
<sup>7</sup> Erik S.Reinert. The role of State in Economic Growth. Centre for Development and the Environment, Oslo, 2000  
<sup>8</sup> Төрийн үүргийн өөр ангилалууд бий. Энэ ч аргагүй юм. Жишээ болгон Humboldt, Wilhelm von, The Sphere and Duties of Government, Bristol, 1996, p. 19  
 Соколинский В.М. Государство и экономика. М., 1997, с. 25 зэргийг үзнэ үү.

Иргэн, байгууллага, төр, олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудын бүгдийн идэвх оролцоог шаардаж буй экологийн асуудалд багш, судлаачид бид ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ?

- Олон улсын хөгжлийн байгууллагуудаас глобаль цаг уурын өөрчлөлт ба экосистемийн өөрчлөлт нь нийгэм-эдийн засгийн амьдралд хэрхэн нөлөөлж байгаа, хэрхэн гамшигийн менежмент, эрсдлийн менежмент системийг боловсронгуй болгох талаар явуулж буй судалгааны ажилд<sup>9</sup> эдийн засагчид өргөнөөр өрсөлдөн оролцож, өөрсдийн судалгааны чиглэлийг орчин үеийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ажиллах;
- Оюутанд зааж буй хичээлүүдээ экологийн агуулгаар баяжуулж, хүний эрхэлж буй тухайн үйл ажиллагаа байгальтай хэрхэн холбогдож, байгаль орчинд ямар нөлөө үзүүлдэг, байгаль орчин буцаад түүнд ямар аюул, боломж учруулдаг тухай тодорхой ярьж, танилцуулж байх;
- Магистрантур, докторантурын түвшинд Хүрээлэн байгаа орчны менежмент (Environmental Management) гэсэн курсыг зааж, энэ сэдвээр ажиллах сонирхолтой суралцагчдыг дэмжих нь зүйтэй юм.

<sup>9</sup> Тухайлбал "Environmental harard-management, advocacy advertising and information", "Emergency Management and Disaster Management System in Mongolia" гэх мэт НҮБХХ-ын төслүүд Монголд хэрэгжээд, дараагийн шатны төслүүд эхэлж байна.